

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024.ж.сарын 05.

№ Т/27

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх заалт, 71 дүгээр 71.1, 71.3, 71.4 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалтууд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн “Эм Жи Эл Акуа” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ**:

- Компанийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж, компанийн хэлбэр өөрчлөгджөн буйтай холбогдуулан Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 09 сарын 18-ны өдөр, 10:00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж-33, Танан төвийн 3 давхарт хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - “Эм Жи Эл Акуа” ХК-ийн дүрэм батлах тухай;
  - ТҮЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, батлах.
  - ТҮЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 08 сарын 26-ны өдрөөр тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2024 оны 08 сарын 08-ны өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2024 оны 08 сарын 23-ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
- Ээлжит бус хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг энэхүү тогтоолын 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа

эзэмшигчид нь энэхүү тогтоолын 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2024 оны 08 сарын 08-ны өдрөөс 2024 оны 09 сарын 17-ны өдөр хүргэл 09<sup>00</sup>-18<sup>00</sup> цагийн хооронд компанийн байранд ирж танилцах, и-мэйлээр авах эсвэл харьялагдах Үнэт Цаасны Компаниас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг энэхүү тогтоолын 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас” хүлээн авах сүүлийн өдрийг харьялагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 1 хоногийн өмнө цаасаар саналыг хүлээн авахаар тогтсугай.
8. Хурлын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Санасэрийг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
  - 9.1. Комиссын дарга: Баттулга овогтой Бат-Оргил (Эм жи эл акуа ХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч)
  - 9.2. Комиссын гишүүд:

Б.Ундрал (Эм жи эл акуа ХК-ийн ТУЗ нарийн бичгийн дарга)  
Ш.Отгонцэцэг (Эм жи эл акуа ХК-ийн маркетингийн албаны дарга)  
Б.Амарбаясгалан (Эм жи эл акуа ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн)  
Б.Намхайдорж (СММ Коммуникаци ба Адвайзорийс ХХК, Зөвлөх үйлчилгээ хариуцсан захирал)

10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
  - 10.1. Комиссын дарга: Г.Намхайдорж (Эм жи эл акуа ХК - ийн үнэт цаас хариуцсан мэргэжилтэн)
  - 10.2. Комиссын гишүүд:
    - Э.Эрхэмзаяа (СММ Коммуникаци ба Адвайзорийс ХХК, Зөвлөх үйлчилгээ, VP)
    - Х.Хүмүүжил (Эм жи эл акуа ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн)
11. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг компанийн Гүйцэтгэх захирал Х.Тэгшээ, Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Бат-Оргилд нарт тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С. АЛТАНТУЯА